

МОНГОЛ-ОРОСЫН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГ  
УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ



"УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ" ХНН-ИЙН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ДАНСНЫ ҮНЭ БА БОДИТ  
ҮНЭ ЦЭНИЙН ЗӨРҮҮГ ТЕСТЛЭХ, ҮНДСЭН ХӨРӨНГӨНД ДАХИН ҮНЭЛГЭЭ ХИЙХ  
ДАВТАМЖИЙГ ТОДОРХОЙЛОХ ЖУРАМ, АРГА АРГАЧЛАЛ БОЛОВСРУУЛАХ,  
МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН ТҮВШИН ТОДОРХОЙЛУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ  
ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын  
нэр:

"УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ" ХНН-ИЙН ҮНДСЭН  
ХӨРӨНГИЙН ДАНСНЫ ҮНЭ БА БОДИТ ҮНЭ ЦЭНИЙН ЗӨРҮҮГ  
ТЕСТЛЭХ, ҮНДСЭН ХӨРӨНГӨНД ДАХИН ҮНЭЛГЭЭ ХИЙХ  
ДАВТАМЖИЙГ ТОДОРХОЙЛОХ ЖУРАМ, АРГА АРГАЧЛАЛ  
БОЛОВСРУУЛАХ, МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН ТҮВШИН  
ТОДОРХОЙЛУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ

Тендер шалгаруулалтын  
дугаар:

УБТЗ/2024/ХА/Ү/03

Улаанбаатар хот

2024 он

## I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ) .....	1
1. Тендерийн цар хүрээ .....	1
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг.....	1
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж .....	1
4. Сонирхогч этгээд, оролцогч.....	2
5. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ .....	2
6. Нийлүүлэх барааны гарал үүсэл.....	2
7. Тендер шалгаруулалтын баримт бичиг .....	3
8. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах .....	3
9. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт .....	3
10. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл..	3
11. Тендерийн иж бүрдэл .....	4
12. Тендерийн жишиг маягууд .....	5
13. Хувилбарт санал .....	5
14. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг .....	5
15. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг .....	5
16. Чадавхын болон туршлагын шаардлага .....	7
17. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт.....	7
18. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт .....	8
19. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт.....	8
20. Тендерийн валют .....	9
21. Тендер хүчинтэй байх хугацаа .....	9
22. Тендерийн баталгаа .....	9
23. Тендер баталгаажуулах, илгээх .....	9
24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа .....	10
25. Тендерийн талаар тодруулга авах.....	10
26. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх.....	10
27. Тендерийг үнэлэх.....	10
28. Арифметик алдааг залруулах .....	10
29. Оролцогчид давуу эрх олгох .....	11
30. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт .....	11
31. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох .....	11
32. Тендерийг эрэмбэлэх .....	11
33. Оролцогчийн чадавхыг дахин магадлах .....	11
34. Мэдэгдэл хүргүүлэх .....	11
35. Гүйцэтгэлийн баталгаа .....	12



# I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

## A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- |  |  |
|--|--|
| <b>1. Тендерийн цар хүрээ</b>                        | <b>1.1.</b> Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “бараа” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.<br><br><b>1.2.</b> Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.<br><br><b>1.3.</b> Барааг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой багцын барааг хуулийн 8.1-д зааснаар дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой бол энэ тухай захиалагч өгөгдлийн хүснэгтэд заана. Ийнхүү заасан бол тендер шалгаруулалт, эсхүл түүний багцад зөвхөн Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлнэ.<br><br><b>1.4.</b> Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгт болон зарлалд заана. |
| <b>2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг</b> | <b>2.1.</b> Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.   |
| <b>3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж</b>   | <b>3.1.</b> Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.  |
| <b>4. Худалдан авах ажиллагааны цахим систем</b>     | <b>4.1.</b> Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем ( <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> ) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.  |
| <b>5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх</b> | <b>5.1.</b> Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.  |

- 5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20<sup>1</sup>, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.
- 6. Сонирхогч оролцогч**      **этгээд,**
- 6.1. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.
- 6.2. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.
- 6.3. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.
- 6.4. Тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т заасан үйлчилгээний хураамж төлсөн байна.
- 6.5. ТШЗ-ны 6.4-т заасан үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.
- 7. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ**
- 7.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.
- 7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.
- 7.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.
- 7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.
- 7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 8. Нийлүүлэх барааны гарал үүсэл**
- 8.1. ТШЗ-ны 1.3-т өөрөөр заагаагүй бол гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.

## **Б.АГУУЛГА**

- 9. Тендер шалгаруулалтын баримт бичиг**
- 9.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:
- I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;
  - II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;
  - III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;
  - IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;
  - V Бүлэг. Тендерийн жишиг маягт;
  - VI Бүлэг. Гэрээний нөхцөл.
- 9.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.
- 9.3. Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн тендер бэлтгэнэ.
- 10. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах**
- 10.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтийг хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар захиалагчид гаргах бол Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүргүүлнэ.
- 10.2. ТШЗ 10.1-д заасан хүсэлтэд ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд болохыг нотлох баримтыг хавсаргана.
- 10.3. Тодруулгын дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл захиалагч хуулийн 20.6-д заасны дагуу шийдвэрлэнэ.
- 11. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**
- 11.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана. Захиалагч уулзалтад ТШЗ-ны 6.6-д заасан сонирхогч этгээд, түүний төлөөллийг оролцуулна.
- 11.2. ТШЗ-ны 11.1-д заасан уулзалтад оролцоогүй нь аж ахуй эрхлэгчийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.
- В. ТЕНДЕР БЭЛТГЭХ**
- 12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл**
- 12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

- 12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн ТШЗ-ны 12.1-д заасан хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.
- 12.3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн хэл болон гадаад хэлээрх хувилбар хоорондоо зөрвөл ТШЗ-ны 12.1-д заасан хэлээр бэлтгэсэн тендер шалгаруулалтын баримт бичгийг баримтална.
- 12.4. Захиалагч ТШЗ-ны 12.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

### **13. Тендерийн иж бүрдэл**

- 13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн бараа нийлүүлэх техникийн болон үнийн санал байна.
- 13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:
  - 13.2.1. ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэсэн маягтууд;
  - 13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;
  - 13.2.3. захиалагч зөвшөөрсөн бол ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;
  - 13.2.4. оролцогч ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;
  - 13.2.5. санал болгож буй бараа ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;
  - 13.2.6. бараа нийлүүлэлтийн хуваарь;
  - 13.2.7. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 18, ТШЗ 19, ТШЗ 20 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;
  - 13.2.8. ТШЗ-ны 21 дүгээр зүйлд заасан барааны үнийн задаргаа;
  - 13.2.9. ТШЗ-ны 21.9-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;
  - 13.2.10. түншлэл бол хуулийн 6.3-т заасан түншлэлийн гэрээ.

- |  |               |  |
|--|---------------|--|
| <b>14. Тендерийн маягтууд</b>  | <b>жишиг</b>  | 13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.<br>13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.  |
| <b>15. Хувилбарт санал</b>   |               | 14.1. Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтын дагуу илгээнэ.  |
| <b>16. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг</b>   |               | 15.1. Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан заасан тохиолдолд оролцогч хуулийн 11.10-т заасанд нийцэх хувилбарт саналыг тендерт ирүүлж болно.<br>16.1. Оролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.<br>16.2. Монгол Улсын хуулийн этгээд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ.<br>16.3. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:<br>16.3.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;<br>16.3.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;<br>16.3.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.<br>16.4. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 14.2, 14.3-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална. |
| <b>17. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг</b> | <b>нотлох</b> | 17.1. Нийлүүлэхээр санал болгох барааны гарал үүслийн мэдээллийг V бүлгийн <b>Error! Reference source not found.</b> -ын холбогдох хэсэгт бөглөж ирүүлнэ.<br>17.2. Хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй.   |

- 17.3. Оролцогчийн санал болгож буй бараа нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлох баримтыг өгөгдлийн хүснэгтэд зааснаар тендерт ирүүлнэ.
- 17.4. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол оролцогч өөрийн санал болгож байгаа бараанд холбогдох загвар, дээжийг тендер нээх эцсийн хугацаанаас өмнө захиалагчид хүргүүлэх ба шалгалт, туршилтыг хийх ажиллагаанд оролцогчийг өгөгдлийн хүснэгтэд зааснаар оролцуулна.
- 17.5. Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно. Санал болгох бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэнийг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг техникийн тодорхойлолттой нийцсэн болохыг хянан үзэх боломжтой баримт, хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарласан тайлбар ирүүлсэн байна.
- 17.6. Барааг нийлүүлснээс хойш өгөгдлийн хүснэгтэд заасан хугацааны туршид тасралтгүй, горимын дагуу ашиглахад шаардагдах өгөгдлийн хүснэгтэд заасан сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалтыг тэдгээрийг авах боломжтой хаяг, үнийн мэдээллийн хамт ирүүлнэ.
- 17.7. Техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал, тоног төхөөрөмжийн загвар, хэмжих нэгж, стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар зэрэг нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.
- 17.8. Гадаадын этгээдийн хувьд гэрээний дагуу хийгдэх техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлөгч гүйцэтгэх тухай баримт;
- 17.9. Монгол Улсын гарал үүсэлтэй бус бараа нийлүүлэхээр санал болгосон оролцогч нь техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээллэл;
- 17.10. Хуулийн 8.4-т зааснаар давуу эрх тооцуулах барааны Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлснээр Сангийн сайдын баталсан Давуу эрх олгох аргачлал, зааврын дагуу тооцно. Барааны үнийн задаргаанд Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг заагаагүй, эсхүл гарал үүслийг нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх тооцохгүй.

- 17.11. ТШЗ-ны 1.3-т зааснаар нийлүүлэхээр санал болгох бараа Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Нотлох баримт бичиг ирүүлээгүй тохиолдолд тухайн барааг шаардлага хангагүй гэж үзнэ.
- 17.12. Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс нийлүүлэхээр санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 18. Чадавхын болон туршлагын шаардлага**
- 18.1. Захиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн хүснэгтэд заах ба хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална.
- 18.2. Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана. Тухайн бараа, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг захиалагч шаардсан бол түншлэлийн гишүүн тус бүр уг шаардлагыг хангасан байх шаардлагатай. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.
- 18.3. Түншлэл нь ТШЗ-ны 18.1-д заасан доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. Борлуулалтын орлогын хэмжээ, ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг ТШЗ-ны 18.1-д заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
- 18.4. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.
- 19. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт**
- 19.1. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 19.2. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

- 19.3. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.
- 20. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**
- 21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**
- 19.3. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.
- 20.1. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.
- 21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.
- 21.2. Барааны үнийн задаргаанд багц тус бүрийн барааны нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг тусгаж ирүүлнэ.
- 21.3. Оролцогч үнийн хөнгөлөлт санал болгох бол ТШЗ-ны 14-т заасан тендер илгээх маягтад заана.
- 21.4. ТШЗ 21.3-т зааснаар үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг тендерийн үнэ гэж үзнэ.
- 21.5. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсэн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.
- 21.6. Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарыт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
- 21.7. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
- 21.8. ТШЗ-ны 21.2-т заасан барааны үнийн задаргааны нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч тендер илгээх маягтад үнээс зөрүүтэй бол барааны үнийн задаргааны нийт нийлбэрийг тендер илгээх маягтын үнэ гэж үзнэ.

- 21.9. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.
- 22. Тендерийн валют**
- 23. Тендер хүчинтэй байх хугацаа**
- 24. Тендерийн баталгаа**
- 25. Тендер баталгаажуулах, илгээх**
- 22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.
- 23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.
- 23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.
- 23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.
- 24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 24.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрээр ТШЗ-ны 24.1-д зааснаар ирүүлнэ.
- 24.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.
- Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ**
- 25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.
- 25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

- 25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.
- 25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маят 5-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.
- 25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.
- 26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**
- 26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.
- 26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.
- Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ**
- 27. Тендерийн талаар тодруулга авах**
- 27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.
- 28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх**
- 28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасан иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн хянан үзнэ.
- 29. Тендерийг үнэлэх**
- 29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.
- 29.2. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.
- 30. Арифметик алдааг залруулах**
- 30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.
- 30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

<b>31. Давуу эрх олгох</b>		31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн дотоодын бараанд хуулийн 8.4-т зааснаар давуу эрх олгож, дотоодын барааны хэсгийн үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.
<b>32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт</b>		31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендэрээс татгалзах үндэслэл болохгүй.
<b>33. Тендерийн харьцуулах тодорхойлох</b>	үнийг	31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.
<b>34. Тендерийг эрэмбэлэх</b>		32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
<b>35. Оролцогчийн чадавхыг магадлах</b>	дахин	33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална. 33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ. 33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална. 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална. 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадална. 35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 19 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 20 дугаар зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ. 35.3. ТШЗ-ны 33.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.
<b>Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ</b>		
<b>36. Шийдвэр хүргүүлэх</b>		36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.

- 37. Гүйцэтгэлийн баталгаа**
- 37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
- 37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
- 38. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах**
- 38.1. Захиалагч ТШЗ-ны 9.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.
- 38.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

## II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ӨХ)

ТШЗ-ны холбогдох заалт	A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: <b>Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг “Улаанбаатар төмөр зам”</b>
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: <b>“Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн үндсэн хөрөнгийн дансны үнэ ба бодит үнэ цэнийн зөрүүг төстлэх, үндсэн хөрөнгөнд дахин үнэлгээ хийх давтамжийг тодорхойлох журам, арга аргачлал боловсруулах, материаллаг байдлын түвшин тодорхойлуулах зөвлөх үйлчилгээ худалдан авах, УБТЗ/2024/ХА/Y/03</b>
ТШЗ 1.1	Тендерийн урилгын дугаар: М3ХННУБТЗ/20240203403
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: - <b>Багцгүй</b>
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: <b>“Үгүй”</b>
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <b>Өөрийн хөрөнгөөр</b>
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: <b>80,000,000 [Наян сая] төгрөг</b>
B. АГУУЛГА	
ТШЗ 9.1	Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулга авах хаяг: <b>Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Сөүлийн гудамж-42, “УБТЗ”-ын Удирдах газар</b> Утасны дугаар: <b>+976-21-242174</b> Цахим шуудангийн хаяг: <b>nh@ubtz.mn</b> Тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийн хариуг хүсэлт гаргагчийн нэрийг дурдалгүйгээр албан бичгээр гаргаж, түүний хуулбарыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем ( <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> )-д нийтлэх бөгөөд тус тодруулга, нэмэлт мэдээллийг бүх тендерт оролцогчдод нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно. Иймд тендерт оролцохыг сонирхогч этгээдүүд дээрх цахим систем дэх тендерийн урилгын тодруулга, мэдээллийг байнга шалгахыг зөвлөж байна.
ТШЗ 10.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: <b>“Үгүй”</b>
B. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.1	Тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл Тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх

	<p>тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг Монгол улсын баталгаат орчуулгын товчоогоор орчуулуулан ирүүлнэ.</p> <p>Тендерийн материалыг Монгол хэл дээр ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
<b>ТШЗ 15.1</b>	Хувилбарт санал ирүүлэхийг: "Зөвшөөрөхгүй"
<b>ТШЗ 16.1.2</b>	<p>Сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээлэл: Шаардлагатай.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт</li> </ul>
<b>ТШЗ 17.6</b>	<p>Ажил үйлчилгээний хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх эсэх, ирүүлэх бол хугацаа: : [<b>"Тийм"</b>]</p> <p>Ажил үйлчилгээ гүйцэтгэхэд шаардагдах тоног төрөөхөмж, өрөө тасалгаа, ажил үйлчилгээ үзүүлэгч бүрэн хариуцах.</p>
<b>ТШЗ 18.1</b>	<p>Санхүүгийн чадавхын шаардлага <b>"Шаардана"</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Банк санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөргүй "Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт"-ыг <a href="http://www.sainscore.mn">www.sainscore.mn</a>, <a href="http://www.burenscore.mn">www.burenscore.mn</a> аль нэг хаягаар хандан авч тендерт хавсарган ирүүлэх. /Харилцагч банкны тодорхойлолтыг тендерийг үнэлэхэд харгалзан үзэхгүй./</li> <li>2. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдийн лавлагаа;</li> </ol> <p>Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: 2022, 2023 онуудын санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн <a href="http://www.e-balance.mof.gov.mn">www.e-balance.mof.gov.mn</a> мэдээллийн системээс тендерт оролцогчдын санхүүгийн тайлангаас сүүлийн 2 жилийн борлуулалтын орлого, болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана.</p>
<b>ТШЗ 19.1</b>	<p>Үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн шаардлага, шалгуур үзүүлэлт: [<b>"Шаардана"</b>]</p> <p>Тендерт оролцогч компани нь 2021 оноос хойш барилга байгууламж тээврийн хэрэгсэлд ( төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн зэрэг байж болно) хөрөнгийн үнэлгээ хийж байсан туршлагын мэдээлэл , гэрээ, гэрээ дүгнэсэн акт, И-баримт ирүүлэх / Хүснэгт №1 /</p> <ul style="list-style-type: none"> <li>- Үнэлгээчид нь үндсэн хөрөнгөнд ( төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн зэрэг ) хөрөнгийн үнэлгээ хийсэн туршлага, гүйцэтгэж байсан үүргийн /багийн</li> </ul>

	ахлагч , гишүүн үнэлгээчин зэрэг/ мэдээлэл , өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт ирүүлэх . / Хүснэгт №2 /				
№	Албан тушаал	Хүний тоо	Үнэлгээчинээр ажилласан жилийн тоо	Мэргэшлийн шаардлага	
1	Багийн ахлах үнэлгээчин	4	10 ба түүнээс дээш	Үнэлгээчний тусгай зөвшөөрөл эзэмшигч, Хөрөнгийн тэргүүлэх зэргийн үнэлгээчин	
2	Үнэлгээчин	6 аас доошгүй	5 ба түүнээс дээш	Үнэлгээчний тусгай зөвшөөрөл эзэмшигч	
<p>Үнэлгээний багт ажиллах 4-өөс доошгүй үнэлгээчин нь оролцогч компанийн үндсэн ажилтан байх сүүлийн 6 сарын баталгаажсан нийгмийн даатгалын НД8 тайлангийн хуулбар ирүүлэх. Ажилтан нь ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр ажил гүйцэтгэж байгаа бол гэрээний хуулбарыг хавсарган ирүүлэх.</p> <p>- Үнэлгээний багт орж ажиллах үнэлгээчдийн жагсаалт, үнэлгээчдийн боловсрол, ур чадвар, туршлагыг нотлох баримт иргэний үнэмлэх, диплом, мэргэжлийн үнэмлэх, тусгай зөвшөөрлийн хуулбар, өмнөх үйлчлүүлэгчдийн тодорхойлолт зэргийг ирүүлэх /Үнэлгээний шалгуурт 1 багийн ахлагч болон эхний 10 үнэлгээний боловсрол, ур чадварыг харгалзан үзнэ / Хүснэгт №2/</p> <p>Ижил төстэй ажил, үйлчилгээ үзүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: “Шаардлагатай”</p> <ul style="list-style-type: none"> <li>- <b>2022, 2023 оны аль нэг жилд батлагдсан төсөөвт өртгийн үнийн дүнгийн [80] хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажил үйлчилгээ, үнэлгээг гэрээ доод тал нь [1] удаа нийлүүлсэн байх шаардлагатай. гэдгийг / тухайн жилүүдийн аль нэг жилд хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын 1 гэрээний дүн нь заасан хувиас багагүй гэж ойлгоно.</b></li> </ul> <p><b>Ижил төстэй ажил үйлчилгээ нь үндсэн хөрөнгийн үнэлгээ гэж ойлгож болно.</b></p> <p>Ажил үйлчилгээ үзүүлсэн гэрээ ба гэрээ дүгнэсэн акт (протокол эсхүл дүгнэлт эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг)-ын хуулбарыг ирүүлнэ. Мөн төлбөр төлсөнийг нотлох баримт, төлбөрийн е-баримт ирүүлнэ.</p> <p>Оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага:</p> <p><b>[Санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлагыг тогтооход ажил үйлчилгээг үзүүлэхэд зайлшгүй шаардлагатай шалгуур үзүүлэлтийг тусгах ба хувь хэмжээг үндэслэлгүй тогтоохгүй байхыг анхаарна уу. Тавигдах шаардлагын жишээ нь дараах байж болох боловч үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:</b></p> <p><b>Ажил үйлчилгээний борлуулалтын орлогын хэмжээ:</b> 2022, 2023 оны аль нэг жилийн борлуулалтын орлого нь тухайн батлагдсан төсөөвт өртгийн [100] хувиас багагүй байна.</p>					

ТШЗ 19.2	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэх эсэх: <b><u>“Тийм”</u></b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Байгууллагын тухай товч танилцуулга ирүүлнэ.</li> <li>2. Ажил үйлчилгээний үнийн задаргаа ба ажил үйлчилгээ үзүүлэх хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ.</li> <li>3. Тендер нээсэн өдрийн байдлаар Монгол Улсын, өр төлбөр төлүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаагүй, эсхүл татварын, эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх шаардлагатай. /Татвар болон нийгмийн даатгалын тодорхойлолтыг тендерийн баримт бичигт хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-ээр дамжуулан шалгана./</li> <li>4. “УБТЗ” ХНН-ийн зүгээс тендерт оролцогчийн тендерт оролцогчийн татвар, банк, нийгмийн даатгалын хэлтэс, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон холбогдох эрх бүхий байгууллагуудаас тодруулга авахад татгалзах зүйлгүй тухай албан бичиг ирүүлнэ.</li> <li>5. Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан ажлын даалгаврын шаардлага хангасан ажил үйлчилгээг захиалагчид үзүүлэх баталгааг албан бичгээр гаргаж ирүүлнэ.</li> </ol> <p><b>Жич:</b> ТӨХ-д заасан материалуудын аль нэгийг тендерт хавсарган ирүүлээгүй бол тухайн тендерээс татгалзах үндэслэл болно. Мөн ТӨХ-д шаардагдаагүй үнэлгээнд нөлөөлөхүйц бус баримт бичгийг нэмэлтээр ирүүлсэн тохиолдолд үнэлгээнд харгалзахгүй болно.</p>
ТШЗ 19.3	<p>Тусгай зөвшөөрөл: [<b><u>“Шаардана”</u></b>]</p> <ul style="list-style-type: none"> <li>- “Хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл” /Монгол Улсын Сангийн яамнаас олгодог/</li> </ul>
	Хөрөнгийн дахин үнэлгээний тайланг <b>Монгол, Орос</b> хэлээр бэлтгэнэ.
	Хөрөнгийн дахин үнэлгээ хийх зааварчилгаа, аргачлал, үр дүнг санхүүгийн тайланд хэрхэн тусгах талаар инженер техникийн болон санхүү бүртгэлийн ажилтнуудад сургалт зохион байгуулах. Гурвалсан хөтөлбөр ирүүлэх.
	Үнэлгээний ажлын хөтөлбөрт сургалт орох эсэх: <b>Тийм</b>
	Зөвлөхийн ирүүлэх үнийн саналд татвар, төлбөр, хураамж, бүх зардал үнийн саналд багтсан байна.
ТШЗ 21.4	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: [ <b><u>“Тохируулахгүй тогтмол байна”</u></b> ] албан бичгээр ирүүлэх
ТШЗ 24.1	Тендерийн баталгааны дүн: <b><u>[Байхгүй]</u></b>
<b>Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ</b>	
ТШЗ 25.5.	Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:

	Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 5-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.
<b>ТШЗ 26.1.</b>	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: <b>Огноо: 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдөр</b> Цаг: <b>10 цаг 00 минут</b>
<b>ТШЗ 26.2.</b>	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. <b>Огноо: 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдөр</b> Цаг: <b>10 цаг 30 минут</b> Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо УБТЗ-ын Удирдах газрын 3-р байр, 1 давхар, 106 тоот
<b>Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ</b>	
<b>ТШЗ 31.1</b>	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: <b>“Үгүй”</b>
<b>ТШЗ Error! Reference source not found.</b>	Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: <b>[“Тийм”]</b>

Хүснэгт №1

Тендерт оролцогч компанийн хөрөнгөнд үнэлгээ хийсэн ажлын туршлага

Хүснэгт №1

Д/Д	Хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн байгууллагын нэр	Ажил гүйцэтгэсэн хугацаа	Хөрөнгийн үнэлгээ хийсэн үндэслэл, зориулалт	Үнэлсэн хөрөнгийн тоо нэрс, ширхэг	Үнэлгээ хийсэн үндсэн хөрөнгийн байршил /тархан байршилт/	Үнэлгээ хийсэн байгууллага нь СТОУС мөрддөг эсэх
1						
2						
....						

Тайлбар:

Тендерт 2020 оноос хойших гүйцэтгэсэн гэрээт ажлын талаархи мэдээллийг ирүүлэх

Үнэлгээний багийн гишүүдийн ажлын туршлага, боловсролын мэдээлэл

Хүснэгт №2

Д/Д	Үнэлгээчний овог нэр	Үнэлгээний багт гүйцэтгэх үүрэг /багийн ахлах үнэлгээчин, үндсэн үнэлгээчин, гэрээт үнэлгээчин гэх мэт	Үнэлгээчний тусгай зөвшөөрлийн дугаар, хүчинтэй хугацаа	Мэргэшлийн цол зэрэг	Мэргэжил	Үнэлгээчнээр ажилласан жил	Барилга болон байгууламж, үндсэн хөрөнгийн үнэлгээ хийж байсан туршлага, гүйцэтгэж байсан үүрэг
1							
2							
3							
....							

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

[Захиалагч болон үнэлгээний хороо нь худалдан авах барааны техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай барааг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендер шалгаруулалтын баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд оролцогчдод зайлшигүй чухал нөхцөл болно.
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах барааны шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөл худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендеруудийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөөт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.
- Тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана. Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай.
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайллан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.
- Бараа материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.

#### **Зураг, төсөл**

Шаардлагатай бол барааны эскиз, зургийг хавсаргана.

#### **Шалгалт, туршилт**

[Захиалагч оролцогчоос нийлүүлэх гэж буй бараанд үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилт хийсэн болохыг нотлох баримт, үүнтэй холбоотой мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.

*Шаардлагатай тохиолдолд захиалагч загвар, дээжийг шалгаж, туршиж болох ба шалгалт, туршилт хийсний үр дүнд тухайн загвар, дээжийн үндсэн шинж чанар алдагдсан, зориулалтын дагуу дахин ашиглах боломжгүй болсон тохиолдолд оролцогчид буцааж олгохгүй тухай техникийн тодорхойлолтод заана. Бусад тохиолдолд гэрээ байгуулсны дараа шалгарсан оролцогчийн загвар, дээжээс бусад загвар, дээжийг буцааж олгоно.*

*Загвар, дээжийг хэрхэн шалгах, турших тухай тодорхой заана.]*

## Ажлын даалгавар

# "УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ" ХНН-ИЙН ҮНДСЭН ХӨРӨНГҮҮДИЙН ДАНСНЫ ҮНЭ БОЛОН БОДИТ ҮНЭ ЦЭНИЙН ЗӨРҮҮГ ТЕСТЛЭХ, ДАХИН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ДАВТАМЖИЙГ ТОДОРХОЙЛОХД ШААРДЛАГАТАЙ АРГАЧЛАЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

### 1. ЗОРИЛГО

"Улаанбаатар төмөр зам" ХНН (цаашид "УБТЗ" гэх)–ийн санхүүгийн тайланд бүртгэлтэй үндсэн хөрөнгүүдийн дансны үнэ болон бодит үнэ цэнийн зөрүүг тестлэх, үндсэн хөрөнгөнд дахин үнэлгээ хийх давтамжийг тодорхойлох журмыг боловсруулахад шаардлагатай санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, нягтлан бodoх бүртгэлийн олон улсын стандарт, үнэлгээний олон улсын стандарт болон бусад холбогдох хууль эрх зүйн актуудад нийцсэн дэлгэрэнгүй арга аргачлал боловсруулах, үндсэн хөрөнгийн нягтлан бodoх бүртгэлд мөрдөх материаллаг байдлын түвшинг тодорхойлоход оршино.

### 2. ХАМРАХ ХҮРЭЭ

УБТЗ-ын харьяа бие даасан үйл ажиллагаатай Монгол улсын Сэлэнгэ аймгийн Сүхбаатар sumaас Дорноговь аймгийн Замын-Үүд сум, Дорнод аймгийн Баянтүмэнд тархан байршсан бүх салбар нэгжүүдийн санхүүгийн тайланда бүртгэлтэй нийт үндсэн хөрөнгүүдийн дансны үнэ болон бодит үнэ цэнийн зөрүүг тестлэх, үндсэн хөрөнгийн нягтлан бodoх бүртгэлд мөрдөх материаллаг байдлын түвшинг тодорхойлох, дахин үнэлгээ хийх давтамжийг тодорхойлох журмыг боловсруулахад ашиглах аргачлалыг боловсруулна.

### 3. ХИЙГДЭХ АЖЛЫН АГУУЛГА

Гүйцэтгэгч нь:

1. Нийслэл, орон нутгийн байршилаас хамааруулан хөрөнгийн бодит үнэ цэнэд нөлөөлөх гадаад, дотоод орчны шинжилгээ, хүчин зүйлсийг тодорхойлох;
2. Хөрөнгүүдийн дансны болон бодит үнэ цэнийн харьцуулалтын судалгаанд шаардагдах макро орчин, зах зээлийн үнэ, гадаад валютын ханшийн өөрчлөлт, инфляци, эрэлт нийлүүлэлт гэх мэт хөрөнгийн бодит үнэ цэнэд нөлөөлөх гадаад хүчин зүйлсийг судлах шинжилгээний аргачлалыг тодорхойлох;
3. Хөрөнгүүдийн дансны үнэ болон бодит үнэ цэнийн харьцуулалтын судалгааны ажилд суурь үндэс болгон ашиглах хөрөнгийн болон санхүүгийн мэдээлэл, баримт бичгийг тодорхойлох;
4. Хөрөнгүүдийн дансны болон бодит үнэ цэнийн харьцуулалтын судалгааны ажилд үндсэн хөрөнгийн ангилал бүрээс тухайн ангиллын хөрөнгийг төлеөлж чадахуйц хөрөнгүүдийг түүвэрлэн сонгох шалгууруудыг тодорхойлох;

- Хөрөнгүүдийн дансны үнэ болон бодит үнэ цэнийн зөвүүг төстлэх, дахин үнэлгээ хийх давтамж, материаллаг байдлын түвшинг тодорхойлоход хамаарал бүхий хууль, дүрэм, журам, олон улсын стандартуудыг тодорхойлох;
- Хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцох аргачлалуудыг боловсруулж, УБТЗ-ын хөрөнгүүдийн онцлогт уялдуулан аль тохирох аргачлалыг хэрхэн сонгох талаар судалгаа, тайлан боловсруулах;
- Тухайн ангиллын хөрөнгийг төлөвлөж чадахуйц түүврээр сонгогдсон хөрөнгүүдийн бодит үнэ цэнийн төстийн судалгааг хөрөнгийн онцлог, шинж чанартай холбогдуулан хэрхэн хийх талаарх тооцоолол, аргачлалыг боловсруулах;
- УБТЗ-ын үндсэн хөрөнгүүдийн бодит үнэ цэнэ болон дансны үнийн зөвүүг төстлэх, үндсэн хөрөнгөнд дахин үнэлгээ хийлгэх давтамжийг тодорхойлох журам боловсруулахад холбогдох албан тушаалтнуудтай санал солилцох, зөвшилцэх, оролцох;
- Хөрөнгийн бодит үнэ цэнийг тодорхойлох, дансны үнэ болон бодит үнэ цэнийн зөвүүг төстлэх, тооцох аргачлал, дахин үнэлгээ хийх давтамжийг тодорхойлох, хөрөнгийн материаллаг байдлын түвшинг тодорхойлох тооцоо, судалгааг хэрхэн хийх талаар УБТЗ-ын инженер техникийн болон санхүү буртгэлийн ажилтнуудад сургалт зохион байгуулах;

#### **4. ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮН**

- Үйлчилгээ үзүүлсний үр дүнд холбогдох дүрэм, журам, стандартын шаардлагын дагуу бэлтгэсэн арга аргачлал, хүснэгтэн файл, ажлын тайлан (монгол, орос хэл дээрх) байна.
- Тайлангийн явцыг хянах үүднээс урьдчилсан тайлан авах ба урьдчилан тайлан авах хугацааг харилцан тохиролцон гэрээнд тусгана.
- Үйлчилгээ нь чанарын хувьд ажлын даалгаварт тусгагдсан шаардлагад нийцсэн бол тайланг хэвлэмэл болон электрон хэлбэрээр хүлээн авч, Талууд хүлээлгэн өгөх - хүлээн авах актад гарын үсэг зурсны дараа үзүүлсэн үйлчилгээг хүлээн авсанд тооцно.

#### **5. ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ ҮНДСЭН ШААРДЛАГА:**

- Зөвлөх үйлчилгээ нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Үнэлгээний олон улсын стандарт болон Монгол улсын хууль, дүрэм, журамд нийцсэн байна.
- Үйлчилгээ үзүүлэх явцад Захиалагчтай харилцан уялдаа холбоотой ажиллана. Энэхүү техникийн даалгаврын хурээнд харилцан уялдаа холбоотой ажиллана гэдэг нь: үйлчилгээний явцад боловсруулах баримт бичгийн талаар зөвлөгөө авах, зөвшилцэх, захидал бичгээр харилцах явдал юм.
- Үйлчилгээг гүйцэтгэх явцад илэрсэн аливаа чухал асуудлыг цаг тухайд нь захиалагчийн удирдлагуудтай ярилцаж шийдвэрлэх.
- Үйлчилгээг гүйцэтгэх үйл ажиллагааны төлөвлөгөөндөө ажлын талбарт ажиллах цаг, уулзалт болон тайлангуудыг хургуулэх хугацааг урьдчилан тохиролцох.

5. Гүйцэтгэгч болон захиалагчийн харилцаа холбоог үр дүнтэй болгох, мэдээллийн солилцооны аюулгүй байдлыг хангах үүднээс онлайн шугам ашиглах.
6. Гүйцэтгэгч компани болон багийн гишүүд нь үйлчилгээ үзүүлэх явцад олж авсан захиалагчийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулах, өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахыг хориглоно.
7. Гүйцэтгэгч компани нь асуудлыг оновчтой шийдвэрлэн зөвлөгөө өгч чаддаг, ажлаа хугацаанд нь чанартай дуусгадаг багийг ажиллуулах.
8. Үйлчилгээ үзүүлэгч нь хөрөнгийн үнэлгээний буюу аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд байна.
9. Гүйцэтгэгч компанийн хөрөнгийн бодит үнэ цэнийг тодорхойлох, дансны үнэ болон бодит үнэ цэнийн зөвүүг тестлэх, дахин үнэлгээ хийх давтамжийг тодорхойлох, хөрөнгийн материаллаг байдлын түвшинг тодорхойлох тооцоо, судалгаа, арга аргачлал боловсруулах баг нь хөрөнгийн дахин үнэлгээ хийх зохих дадлага, туршлагатай байх.
10. Энэхүү Техникийн даалгаварт тусгагдсан бүх төрлийн үйлчилгээний дагуу Гэрээг биелүүлэхтэй холбоотойгоор Гүйцэтгэгчээс гарах бүх зардал Гэрээний үнэд багтана.
11. Үйлчилгээг үзүүлэх хугацаа: гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс календарьн 45 хоног.

**Ажил үйлчилгээ үзүүлэх хуваарь**

<b>№</b>	<b>Ажлын баримт</b>	<b>Хугацаа</b>	<b>Тайлангийн хэлбэр</b>
<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>
1	<p>1. Үйлчилгээ үзүүлсний үр дүнд холбогдох дүрэм, журам, стандартын шаардлагын дагуу бэлтгэсэн арга аргачлал, хүснэгтэн файл, ажлын тайлан (Монгол Орос хэл дээр) байна.</p> <p>2. Тайлангийн явцыг хянах үүднээс урьдчилсан тайлан авах хугацааг харилцан тохиролцон гэрээнд тусгана.</p> <p>3. Үйлчилгээ нь чанарын хувьд ажлын даалгаварт тусгагдсан шаардлагад нийцсэн бол тайланг хэвлэмэл болон электрон хэлбэрээр хүлээн авч, Талууд хүлээлгэн өгөх – хүлээн авах актад гарын үсэг зурсны дараа үзүүлсэн үйлчилгээг хүлээн авсанд тооцно.</p>	Календарын 45 хоног	<i>Цахим болон хэвлэмэл байдлаар</i>

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

<p>Үнэлгээний шалгуур үзүүлэлт, оноо:  <b>БАГЦ №1 ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ</b></p> <p><b>I. Зөвлөх компани өмнө нь “Хөрөнгийн үнэлгээ” хийж байсан ажлын туршлага:</b></p> <p><input type="checkbox"/> <i>Үйл ажиллагаа эрхэлдэг ажлын байртай эсэх</i> [5]</p> <p style="text-align: center;"><i>Тийм - 5 оноо Үгүй - 0 оноо</i></p> <p><input type="checkbox"/> <i>20.. оноос хойш Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4-р зүйлд заасны дагуу СТОУС мөрддөг аж ахуйн нэгж байгууллагад хөрөнгийн үнэлгээ хийсэн туршлага</i> [10]</p> <ul style="list-style-type: none"> <li>- 5 ба түүнээс дээш гэрээт ажил - 10 оноо</li> <li>- 3-4 гэрээт ажил - 7 оноо</li> <li>- 1-2 гэрээт ажил - 4 оноо</li> </ul> <p><input type="checkbox"/> <i>20.. оноос хойш барилга болон байгууламжид (төмөр зам, эрчим хүч ус хангамжийн байгууламж, барилга, барилгын инженерийн шугам сүлжээ зэрэг) хөрөнгийн үнэлгээ хийж байсан туршлага</i> [10]</p> <ul style="list-style-type: none"> <li>- 5 ба түүнээс дээш гэрээт ажил - 10 оноо</li> <li>- 3-4 гэрээт ажил - 7 оноо</li> <li>- 1-2 гэрээт ажил - 4 оноо</li> </ul> <p><input type="checkbox"/> <i>МУ-ын нутаг дэвсгэрт тархан байршил хөрөнгөтэй байгууллагын тархан байршил хөрөнгөнд 2021 оноос хойш үнэлгээ хийж байсан туршлага</i> [5]</p> <ul style="list-style-type: none"> <li>- 3 ба түүнээс дээш гэрээт ажил - 10 оноо</li> <li>- 1-2 гэрээт ажил - 5 оноо</li> </ul> <p><b>II. Зөвлөхийн санал болгож буй ажлын хөтөлбөр болон аргачлал нь ажлын даалгаврын шаардлагад нийцсэн байдал</b> [30]</p> <p><input type="checkbox"/> <i>Санал болгож буй үнэлгээний ажлын арга аргачлал, хөтөлбөр нь захиалгчийн ажлын даалгаварт нийцсэн эсэх</i> [10]</p> <ul style="list-style-type: none"> <li>- 0-10 хүртэл оноо</li> </ul> <p><input type="checkbox"/> <i>Үнэлгээчдийн нэрс болон ажил үүргийн хуваарь, ажил гүйцэтгэх хугацааг тодорхой заасан ажил үүргийн хуваарь ирүүлсэн эсэх</i> [10]</p> <ul style="list-style-type: none"> <li>- 0-10 хүртэл оноо</li> </ul> <p><input type="checkbox"/> <i>Хөрөнгийн дахин үнэлгээ хийх зааварчилгаа, аргачлал, үр дүнг санхүүгийн тайланд хэрхэн тусгах талаар сургалтын хөтөлбөр бэлтгэсэн эсэх</i> [10]</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тийм - 10 оноо</li> <li>- Үгүй - 0 оноо</li> </ul> <p><b>III. Үнэлгээчдийн чадвар болон туршлага</b> [40]</p> <p><input type="checkbox"/> <i>Багийн ахлагч нь хөрөнгийн тэргүүлэх зэргийн үнэлгээчин эсэх</i> [10]</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тийм - 10 оноо</li> <li>- Үгүй - 0 оноо</li> </ul>	
---	--

Багийн ахлагч нь 2021 оноос хойш барилга болон байгууламжид ( төмөр зам мөн эрчим хүч ус хангамжийн байгууламж , барилга, барилгын инженерийн шугам сүлжээ зэрэг ) хөрөнгийн үнэлгээ хийсэн багийг удирдан ажиллаж байсан туршилага

[10]

- Тийм - 10 оноо
- Үгүй - 0 оноо

Гишүүн үнэлгээчдийн ( багийн ахлагчаас бусад ) 2017 оноос хойш барилга болон байгууламжид ( төмөр зам мөн эрчим хүч ус хангамжийн байгууламж , барилга, барилгын инженерийн шугам сүлжээ зэрэг ) үндсэн хөрөнгийн үнэлгээ хийж байсан туршилага

[10]

- 0 - 10 хүртэлх оноо

Багийн гишүүдийн 5-аас дээш жил үнэлгээчинээр ажилласан туршилага

[10]

- 0 - 10 хүртэлх оноо

**Нийт оноо: 100**

**Авбал зохих техникийн доод оноо: 70**

## V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТУУД

Маягт 1. Тендер илгээх маягт

Маягт 2. Барааны үнийн задаргаа

Маягт 3. Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл

Маягт 4. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Маягт 5. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Маягт 6. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

**[Захиалагч байгууллагын нэр]-д**

Манай **[оролцогчийн нэр]** нь танай байгууллагаас зарласан **[тендер шалгаруулалтын нэр, дугаар]** тендер шалгаруулалтад **[үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “**тендер**” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцохтой холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна. Үүнд:
  - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
  - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
  - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй;
  - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт **[“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих]. [Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих].**
5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш **[30 ба түүнээс дээш хоногийн тоо]** хоногийн хугацаанд хүчинтэй байна.<sup>1</sup>
6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

<sup>1</sup> Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол “5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.” гэж сольж бичнэ үү.

*[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,  
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,  
албан тушаал, гарын үсэг,  
байгууллагын тамга, тэмдэг]:*

**Хаяг**



**Маягт 2      Ижил төстэй ажил үйлчилгээ үзүүлсэн гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

**Маягт 3      Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Оролцгчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

Маягт 5

**Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт**

	<b>Нууцалсан баримт бичиг, мэдээлэл</b>	<b>Хүний эмзэг мэдээлэлд хамаарах хууль зүйн үндэслэл</b>
1.		
2.		
3.		
4.		
5.		

## VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

### Санамж

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж бараа худалдан авахад энэхүү гэрээний нөхцөлийг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас бараа, түүнтэй холбогдох үйлчилгээг худалдан авах харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсрулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн бараа худалдан авах нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн бараа худалдан авахад хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. ГТН-д заасан зарим жишээ, нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
7. Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан гэрээ байгуулах албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалттай танилцаж, судалсан байх шаардлагатай болохыг анхаарна уу.

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

### НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

1.1. Гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл нь дор дурдсан утгыг агуулна:

- 1.1.1. “Бараа” гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;
- 1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;
- 1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
- 1.1.4. “Нийлүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
- 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нэрлэснийг;
- 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
- 1.1.7. “Бараа нийлүүлэх нөхцөл” гэж Захиалагчийн техникийн тодорхойлолтод нийцүүлж Тендерт тусгасан бараа бэлтгэх, нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг ойлгоно. Тендерт тусгайлан заагаагүй бараа нийлүүлэх нөхцөлийг Техникийн тодорхойлолтод тусгаснаар ойлгоно. Хуулийн 30.2, 34.2-т зааснаар хэлэлцээ хийсэн тохиролцоо нь Гэрээнд тусгагдсан бол Бараа нийлүүлэх нөхцөлийн нэг хэсэг болно.
- 1.1.8. “Бараа нийлүүлэх газар” гэж барааг хүлээлгэн өгөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;
- 1.1.9. “Доголдол” гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;
- 1.1.10. “Баталгаат хугацаа” гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад бараанд илэрсэн доголдлыг нийлүүлэгч хариуцах хугацааг;
- 1.1.11. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлага гаргах хугацааг;
- 1.1.12. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй

холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;

1.1.13. “Нийлүүлэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс томилогдсон этгээдийг;

1.1.14. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

Гэрээний тайлбар

- 1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:
- 1.2.1. Ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно.
  - 1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.
  - 1.2.3. Зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.
  - 1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсэн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.
  - 1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсэн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

## ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ

Бараа нийлүүлэх

- 2.1 Нийлүүлэгч нь гэрээнд заасан бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.
- 2.2 Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад эдгээрт өөрчлөлт орох зайлшгүй

	шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна.
Бараа нийлүүлэх газар	2.3 ГЕН-ийн 2.2-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.
Бараа нийлүүлэх хугацаа, түүнийг сунгах	2.4 Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг хүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.
Барааг хүлээлгэн өгөх	2.5 Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана.
Барааны гарал үүслийн улс	2.6 Бараа нийлүүлэх хугацааг нийлүүлэлтийн хуваарийг үндэслэн ГТН-д заана.
Баглаа боодол	<p>2.7 Нийлүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд бараа нийлүүлэлтийн хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:</p> <p>2.7.1 Захиалагч ГЕН-ийн 2.4-д заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;</p> <p>2.7.2 Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон.</p> <p>2.8 Захиалагч ГЕН-ийн 2.7-д заасан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл Нийлүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.</p> <p>2.9 ГЕН-ийн 2.7.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй.</p> <p>2.10 Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.</p> <p>2.11 Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ.</p> <p>2.12 Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна.</p> <p>2.13 Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийг нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь заавал Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна.</p> <p>2.14 Нийлүүлэгч барааг ГЕН-ийн 2.5-д заасан газар хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудах, дутах зэрэг доголдлоос урьдчилан сэргийлэх сав, баглаа боодлыг ГТН-д заасны дагуу хангана.</p> <p>2.15 Сав, баглаа боодол, түүний хаягдал нь хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар сонгоно. Сав, баглаа боодолд хууль тогтоомжоор хориглосон материал ашиглахыг хориглоно.</p>

	2.16 Нийлүүлэгч баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг мөрдөнө.
Худалдааны нөхцөл	2.17 Гэрээнд Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хэрэглэх бол тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 20.6-д заасан нөхцөлийг ГТН-д тусгана.
	2.18 ГТН-д заагаагүй бол Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
Гүйцэтгэлийн баталгаа	<p>2.19 Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Нийлүүлэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн З хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Нийлүүлэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.</p> <p>2.20 Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Нийлүүлэгчийн Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангулна:</p> <ul style="list-style-type: none"> <li>2.20.1 Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;</li> <li>2.20.2 Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;</li> <li>2.20.3 Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.</li> </ul> <p>2.21 Захиалагч гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангулсан нь Нийлүүлэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.</p> <p>2.22 ГЕН-ийн 2.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Нийлүүлэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.</p> <p>2.23 Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 4.11-д заасан Чанарын баталгаа гаргасан тохиолдолд Гүйцэтгэлийг баталгааг чөлөөлнө.</p>
	<b>ГУРАВ. ЗАХИАЛАГЧ</b>
Барааг хүлээн авах	3.1 Захиалагч нь барааг хүлээн авч, хүлээлцсэн баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.
Шалгалт, туршилт	<p>3.2 Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ.</p> <p>3.3 Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ.</p>

- 3.4 ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна.
- 3.5 Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдолтой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.
- 3.6 Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна.
- Гэрээний үнэ**
- 3.7 Гэрээний үнийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 3.8 Гэрээний үнэд хуулийн 40.4-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д заана.
- Төлбөр төлөх**
- 3.9 Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Нийлүүлэгчид төлнө.
- 3.10 Нийлүүлэгчийн хүсэлтээр Захиалагч Бараа нийлүүлэх хугацааг ГЕН-ийн 2.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.
- 3.11 Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.
- 3.12 Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.
- 3.13 ГЕН-ийн 3.8-д заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.
- 3.14 Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.
- 3.15 Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс суутгана.
- ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА**
- Захиалагчийн хүлээх эрсдэл**
- 4.1. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:
- 4.1.1. Барааг захиалагчид шилжүүлснээс хойш бараа нь ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар гэмтсэн, устсан;
- 4.1.2. Нийлүүлэгч Барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх тодорхой үйлдэл хийсэн боловч Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн аваагүй (доголдолтой бараанд хамаarahгүй) байх хугацаанд ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар Бараа гэмтсэн, устсан.
- Даатгал**
- 4.2. Нийлүүлэгч нь барааг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрсдэлээс хамгаалж ГТН-д заасны дагуу даатгуулж, даатгалын

- гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг Захиалагчид ирүүлнэ. Даатгалын хураамжийг Нийлүүлэгч хариуцна.
- Доголдол
- 4.3. Захиалагч бараа, дагалдах үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар Нийлүүлэгчид мэдэгдэнэ.
  - 4.4. Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор барааны далд хэсгийг нээх, шалгалт, туршилт хийх эрхтэй.
  - 4.5. Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид өгнө.
  - 4.6. Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бур Нийлүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.
  - 4.7. Нийлүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана.
  - 4.8. Захиалагчийн гаргасан зардлыг Нийлүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө.
  - 4.9. Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас суутгаж болох бөгөөд Чанарын баталгаа хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Нийлүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнө.
- Чанарын баталгаа
- 4.10. Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг ГТН-д заана.
  - 4.11. ГТН-д заасан бол чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно.
  - 4.12. Нийлүүлэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаажуулж болно.
  - 4.13. ГЕН-ийн 4.12-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.
  - 4.14. Баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Бараанд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.
  - 4.15. ГЕН-ийн 4.7-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Нийлүүлэгчид олгоно.
  - 4.16. ГЕН-ийн 4.7-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.
  - 4.17. Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд хугацаа

	хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.
Оюуны өмчийн эрх зөрчих	4.18. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид төлнө.
Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал	4.19. Барааг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.
Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа	4.20. Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.10-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно. 4.21. Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна. 4.22. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцэж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна. 4.23. Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Нийлүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Нийлүүлэгч ГЕН-ийн 2.7-д заасан хүсэлт гаргаж болно.
Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл	4.24. Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нөгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна. 4.25. Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд эсхүл Нийлүүлэгч ГЕН-ийн 2.13-т заасныг зөрчсөн бол нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.

## **ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ**

- 5.1. Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээнээс татгалзах эсхүл гэрээг цуцлах эрхтэй:
- 5.1.1. Нийлүүлэгч гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч нэмэлт хугацаанд гүйцэтгээгүй;

- |  |  |
|--|--|
| <p>Гэрээнээс татгалзах,<br/>гэрээг цуцлах мэдэгдэл</p> | <p>5.1.2. Бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон;</p> <p>5.1.3. Нийлүүлэгч ГЕН-ийн 6.5-д заасан үүргээ зөрчсөн нь тогтоогдсон.</p> <p>5.1.4. Нийлүүлэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй.</p> <p>5.2. Нийлүүлэгч тендерт оролцох буюу бараа нийлүүлэх явцдаа авлига өгсөн, залилах гэмт хэрэг үйлдсэн нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.</p> <p>5.3. Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно.</p> <p>5.4. Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.</p> <p>5.5. Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээг дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.</p> |
| <p>Төлөөлөгч</p>                                       | <p><b>ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ</b></p> <p>6.1. Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маяттад заана.</p> <p>6.2. Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна.</p> <p>6.3. Гэрээ хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ.</p> <p>6.4. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.</p>   |
| <p>Туслан гүйцэтгэгч</p>                               | <p>6.5. Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж байгаа тохиолдолд Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт зааснаас илүү хувийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.</p> <p>6.6. Туслан гүйцэтгэгчийн аливаа зөрчлийг (хугацаа хэтрүүлэх, ажлын догоилдол гэх мэт) Нийлүүлэгч хариуцах бөгөөд Туслан гүйцэтгэгч өөрчлөгдсөн тохиолдолд ГЕН-ийн 2.3-д заасан журмыг баримтална.</p>   |
| <p>Нууцлал</p>   | <p>6.7. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал</p>  |

- зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.
- 6.8. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.
- Мэдэгдэл
- 6.9. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.
- 6.10. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.9 -д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.
- 6.11. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан Төлөөлөгчийн хаягаар илгээнэ.
- 6.12. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:
- 6.12.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн;
- 6.12.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.
- 6.13. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
- 6.14. ГЕН-ийн 6.13-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.
- Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах
- 6.15. Дараах тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна:
- 6.15.1. ГЕН-ийн 2.8-т заасны дагуу хугацаа сунгагдсан;
- 6.15.2. үнийн тохируулга хийсэн.
- 6.16. Гэрээний нэмэлт, өөрчлөлтөд талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
- 6.17. ГЕН-ийн 6.15-д зааснаас бусад тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.
- Маргаан шийдвэрлэх
- 6.18. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрлөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 6.19. Талууд зөвшилцөн, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

<b>ГЕН 4.1.</b>	Үйлчилгээ эхлэх хугацаа: <b>[Гэрээ байгуулсан өдрөөс эхлэнэ]</b>
<b>ГЕН 4.9.</b>	Үйлчилгээний явцын тайлан гаргах хуваарь болон ирүүлэх хугацаа: <b>[Ажил үйлчилгээ үзүүлэх хувиарийн дагуу]</b>
<b>ГЕН 5.2.</b>	Үнийн тохироулга: <b>[“Хийхгүй”]</b>
<b>ГЕН 5.4.</b>	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: <b>[“Үгүй”]</b>
<b>ГЕН 5.6.</b>	Төлбөр төлөх хугацаа: <b>[Гэрээ дүгнэсэн акт үйлдсэнээс хойш 30-60 хоногт]</b>
<b>ГЕН 7.5.</b>	Даатгал: <b>[Үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд нь өөрийн үйл ажиллагаатай холбогдуулан гарч болох эрсдэлүүдийн даатгалыг бүрэн хариуцна]</b>
<b>ГЕН 10.21.</b>	Захиалагчийн төлөх алдангийн хувь: Алдангийн хувь: <b>[ хоног тутамд 0.01 хүртэл хувиар тогтоож бичих]</b>
<b>ГЕН 10.22.</b>	Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь: Алдангийн хувь: <b>[ хоног тутамд 0.01 хүртэл хувиар тогтоож бичих]</b>

## ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.  
Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэрийг бичих] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэрийг бичих] (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Бараа” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь [гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дунг тоогоор болон үсгээр бичих] төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Нийлүүлэгч [Нийлүүлэгчийн нэрийг бичих]-ийн харилцах [Банкны нэрийг бичих] банкны [дансны дугаар бичих] дугаар дансанд шилжүүлнэ.
3. Доор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
  - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - 3.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;
  - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
  - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
  - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
  - 3.6. Техникийн тодорхойлолт;
  - 3.7. Бараа нийлүүлэлтийн хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
  - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх-ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан:
  - 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх-ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

## ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: **2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр**

Тендер шалгаруулалтын төрөл: Ажил үйлчилгээ

Тендер шалгаруулалтын нэр: "Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн үндсэн хөрөнгийн дансны үнэ ба бодит үнэ цэнийн зөрүүг тестлэх, үндсэн хөрөнгөнд дахин үнэлгээ хийх давтамжийг тодорхойлох журам, арга аргачлал боловсруулах, материаллаг байдлын түвшин тодорхойлуулах зөвлөх үйлчилгээ худалдан авах тендер

Тендер шалгаруулалтын дугаар: **[УБТЗ/2024/ХА/Y/03]**

Нийт төсөвт өртөг: **80,000,000 (наян сая) төгрөг**

Тендер шалгаруулалтын арга: Нээлттэй

1. **Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг "Улаанбаатар төмөр зам"** нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: [**"Үгүй"**]
3. Тендерийг **[2024 оны 06 дугаар сарын 13]-ны өдрийн, [10:00 цаг]**—аас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг **[2024 оны 06 дугаар сарын 13]-ны өдрийн, [10:30 цаг]-т** нээнэ.
4. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: [**"Зөвшөөрөхгүй"**]
5. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: [**"Эрхгүй"**]
6. Тендер нь түүнийг нээнээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
7. Тендерийн баталгаа шаардах эсэх: [**"Үгүй"**] Тендерийн баталгаа шаардах бол тендер шалгаруулалтын баримт бичгийн заасан үнийн бүхий тендерийн баталгааг холбогдох журмын дагуу цахим системээр ирүүлснээр тендер нээх болохыг анхаарна уу.
8. Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: [**"Үгүй"**]
9. Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: [**"Үгүй"**]
10. Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

**Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Сөүлийн гудамж-42,  
"УБТЗ"-ын Удирдах газар**

Утасны дугаар: **+976-21-242174**

Цахим шуудангийн хаяг: **[nh@ubtz.mn](mailto:nh@ubtz.mn)**